

ХАНБОГД СУМЫН УДИРДЛАГА, МАЛЧДЫН ТӨЛӨӨЛӨЛ БОЛОН ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙН ХЭЛЦЛИЙН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Ханбогд сум

Их булаг

2015 оны 3 дугаар сарын 19-20

Та бүхэнд Олон улсын санхүүгийн корпорацийн омбудсмэн (CAO) байгууллагын оролцоотой маргааныг шийдвэрлэх Малчдын төлөөлөгчид, Сумын удирдлага болон “Оюу толгой” компанийн хамтарсан уулзалтаар тохирсон асуудлын тухай мэдээлдэг билээ. Энэ удаагийн хурал 2015 оны 3 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Ханбогд сумын Техникийн сургалтын төвд хийгдсэн бөгөөд уулзалтын тойм мэдээг та бүхэнд хүргүүлж байна. Энэхүү уулзалтын гол зорилго нь орон нутгийн удирдлага, малчдын төлөөлөл болон “Оюу толгой” компани цаашид CAO байгууллагын оролцоогүйгээр малчдад тулгамдаж буй асуудлаар зөвшилцөх гурван талт Зөвлөл байгуулах Харилцан ойлголцлын санамж бичиг, Зөвлөлийн дүрмийн төслийг эцэслэх мөн уурхайн талбайд мал бэлчээрлүүлэх, ус түр зөөх журмуудыг хэлэлцэх байлаа.

Уулзалтыг CAO-ын газрын зуучлагч чиглүүлж, Ханбогд сумын Засаг даргын орлогч Х.Отгонжаргал, Баян багийн Засаг дарга М.Мягмаржав, сумын Байгаль орчин, уул уурхай хариуцсан мэргэжилтэн Б.Алтангэрэл, Малчдын төлөөлөл болон “Оюу толгой” компанийн төлөөллүүд оролцлоо.

Уулзалтын үр дүнд талууд:

- Орон нутгийн удирдлага, малчдын төлөөлөл болон “Оюу толгой” компанийн хамтарсан гурван талт Зөвлөл байгуулах Харилцан ойлголцлын санамж бичиг, Зөвлөлийн дүрмийн төслийг эцэслэв.
- Хөндлөнгийн шинжээчдийн багийн 1-р шатны тайланг холбогдох талуудад танилцуулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхээр тохирлоо.
- Уурхайн талбайд мал бэлчээрлүүлэх болон уурхайгаас 20 км-ын зайд байдаг худаг усны хүндрэлтэй малчдад уурхайгаас түр ус зөөх түр журмуудыг хэлэлцэн батлаж 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн мөрдөхөөр тохиров.
- Олон талт мэргэжлийн шинжээчдийн баг ажиллуулах сонирхолоо илэрхийлэх урилгын төслийг эцэслэж, олон нийтэд нээлттэй зарлахаар болов.

Мөн энэ удаагийн уулзалтын үеэр “Оюу толгой” ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал Айван Велла биеэр хүрэлцэн ирж Үндэйн голын урсацыг хэсэгчлэн өөрчлөх ажлыг гүйцэтгэхдээ энэ ажлын талаар нутгийн малчдад бүрэн гүйцэд тайлбарлаж, зөвлөлдөөгүүдээ хүлцэл өчиж, уучлалт гуйсан захидлыг компанийн нэрийн өмнөөс Малчдын төлөөлөлд гардуулан өглөө.

Ханбогд сумын удирдлага
Ханбогд сумын Малчдын төлөөлөгчид
“Оюу толгой” ХХК